

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/108/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАТСҮМБЭР СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2021 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Уваа Уул Аудит ХХК

Захирал: Ч.Мөнхтуяа

Цахим хаяг: uwaauul.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. АУДИТЫН ТАЙЛАН	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Материаллаг байдал	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.10 Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт	19
4.3 Зөвлөмж.....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
НХМ	Нэг хэвийн маягт
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/118
танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Батсүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Батсүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

19020380

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	69,107,724.45	307,370,369.27
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	22,092,365.39
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	22,092,365.39
3121	Төгрөг	00.00	22,092,365.39
31211	Төрийн сангийн харилцах	00.00	9,565,627.39
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	00.00	12,526,738.00
33	АВЛАГА	8,607,530.50	159,195,867.98
335	Бусад авлага	8,607,530.50	159,195,867.98
3351	Байгууллагаас авах авлага	1,222,861.43	155,673,600.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	7,384,669.07	3,522,267.98
35	БАРАА МАТЕРИАЛ	60,500,193.95	126,082,135.90
351	Түүхий эд материал	28,907,175.97	78,607,971.04
35110	Тусгай зориулалттай материал	154,500.00	1,891,975.00
35130	Эм боох материал	28,752,675.97	76,715,996.04
354	Хангамжийн материал	31,557,069.98	47,474,164.86
35410	Бичиг хэргийн материал	664,800.00	780,600.00
35420	Аж ахуйн материал	315,950.00	130,400.00
35430	Сэлбэг хэрэгсэл	220,000.00	540,000.00
35450	Барилгын засварын материал	00.00	2,590,800.00
35460	Хүнсний материал	501,414.40	680,020.00
35470	Бусад хангамжийн материал	29,854,905.58	42,752,344.86
35600	Мал амьтад	35,948.00	00.00
36	НӨӨЦИЙН БАРАА	00.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	373,587,883.47	371,867,209.33
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	373,587,883.47	371,867,209.33
392	Биет хөрөнгө	364,317,633.51	362,436,542.77
39201	Барилга, байгууламж, орон сууц	399,051,079.13	399,051,079.13
39202	Хуримтлагдсан элэгдэл	-134,622,374.89	-141,632,540.41
39203	Авто-тээврийн хэрэгсэл	57,186,434.00	57,186,434.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-42,384,259.43	-48,410,331.83
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	156,343,641.73	184,967,340.74
39206	Хуримтлагдсан элэгдэл	-79,413,340.19	-99,202,074.97
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,434,144.01	22,092,444.01
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11,197,642.85	-12,565,759.90
39217	Ном	919,952.00	949,952.00
393	Биет бус хөрөнгө	9,270,249.96	9,430,666.56
39301	Програм хангамж	400,000.00	675,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-400,000.00	-445,833.36
39303	Бусад биет бус хөрөнгө	9,339,000.00	9,339,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-68,750.04	-137,500.08
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	442,695,607.92	679,237,578.60
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	776,072.14	1,992,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	776,072.14	1,992,000.00
413	Өглөг	776,072.14	1,992,000.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	19,177.00	00.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	234,145.14	1,442,000.00
4136	Бусад өглөг	522,750.00	550,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	366,550.00	550,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	156,200.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	441,919,535.78	677,245,578.60
51	Засгийн газрын хувь оролцоо	441,919,535.78	677,245,578.60

Төв аймгийн Батсүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	410,076,192.40	410,076,192.40
51101	Өмч: - төрийн	410,076,192.40	410,076,192.40
512	Хуримтлагдсан үр дүн	-114,177,005.25	121,149,037.57
51210	Өмнөх үеийн үр дүн	-114,177,005.25	-114,177,005.25
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	235,326,042.82
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	146,020,348.63	146,020,348.63
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	442,695,607.92	679,237,578.60

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	630,864,770.00	1,522,233,160.16
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	553,266,385.00	563,747,385.16
120	Нийтлэг татварын бус орлого	64,077,185.00	554,527,077.88
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	64,077,185.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	64,077,185.00	00.00
120012	Эрхийн шимтгэлийн орлого /ТӨҮГ/	00.00	13,843,999.01
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /ҮХ/	00.00	540,683,078.87
122	Тусламжийн орлого	4,017,500.00	9,220,307.28
122001	Хандив тусламж /дотоод/	4,017,500.00	9,220,307.28
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	485,171,700.00	00.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	485,171,700.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	34,413,465.00	463,102,775.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,130,000.00	00.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	1,130,000.00	00.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	43,184,920.00	495,383,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,549,465.00	217,211,255.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,214,965.00	202,098,255.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,334,500.00	15,113,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	17,734,000.00	52,982,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	17,734,000.00	52,982,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	00.00	192,909,020.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	192,909,020.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	648,367,750.79	1,286,907,117.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	648,367,750.79	1,286,907,117.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	641,448,490.67	1,271,370,921.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	399,638,160.95	464,347,561.80
210101	Үндсэн цалин	282,597,843.95	230,210,374.50
210102	Нэмэгдэл	84,945,108.50	192,585,788.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,847,130.50	4,179,862.00
210104	Урамшуулал	29,248,078.00	37,371,537.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,685,385.92	56,336,527.00
210201	Тэтгэврийн даатгал	34,561,073.70	38,361,746.12
210202	Тэтгэмжийн даатгал	4,167,399.67	4,174,433.04
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,424,385.51	3,322,745.78
210204	Ажилгүйдлийн даатгал	833,499.45	792,988.68
210205	Эрүүл мэндийн даатгал	6,699,027.59	9,684,613.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,383,240.80	50,987,250.10
210301	Гэрэл, цахилгаан	7,157,105.00	5,322,836.00
210302	Түлш, халаалт	11,226,135.80	45,476,414.10
210303	Цэвэр, бохир ус	00.00	188,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	39,179,758.10	31,053,129.00
210401	Бичиг хэрэг	3,964,944.00	3,747,800.00

Төв аймгийн Батсүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210402	Тээвэр, шатахуун	20,743,380.00	20,695,220.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,115,748.00	1,362,459.00
210404	Ном, хэвлэл	1,550,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,923,050.00	5,247,650.00
210408	Бараа материал акталсны зардал	6,882,636.10	00.00
2105	Нормативт зардал	83,041,365.31	628,291,102.98
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	72,850,059.71	616,023,683.58
210502	Хоол, хүнс	10,191,305.60	12,267,419.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,433,400.00	4,079,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	272,500.00	00.00
210604	Урсгал засвар	2,160,900.00	4,079,900.00
2107	Томилолт, зочны зардал	750,500.00	646,000.00
210702	Дотоод албан томилолт	750,500.00	646,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	632,500.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	58,500.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	00.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	250,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	48,704,179.60	35,629,450.46
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,252,625.00	1,321,777.31
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	46,451,554.60	34,307,673.15
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,919,260.12	15,536,196.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	15,536,196.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	15,536,196.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,919,260.12	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,919,260.12	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-17,502,980.79	235,326,042.82
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	10,130,190.05	00.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	10,130,190.05	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	10,130,190.05	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-7,372,790.74	235,326,042.82

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	410,076,192.40	146,020,348.63	(114,177,005.25)	441,919,535.78
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	410,076,192.40	146,020,348.63	(114,177,005.25)	441,919,535.78
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	410,076,192.40	146,020,348.63	(114,177,005.25)	441,919,535.78
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	235,326,042.82	235,326,042.82
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	410,076,192.40	146,020,348.63	121,149,037.57	677,245,578.60

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	562,770,085.00	803,362,175.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	485,171,700.00	550,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	550,000.00
120009	Бусад орлого	00.00	550,000.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	485,171,700.00	00.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	485,171,700.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	77,598,385.00	802,812,175.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,130,000.00	00.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	1,130,000.00	00.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	43,184,920.00	495,383,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,549,465.00	94,471,255.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,214,965.00	79,358,255.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,334,500.00	15,113,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	17,734,000.00	52,982,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	17,734,000.00	52,982,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	00.00	159,975,420.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	159,975,420.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	555,850,824.88	765,076,809.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	555,850,824.88	765,076,809.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	555,850,824.88	718,071,722.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	399,588,300.96	425,848,030.31
210101	Үндсэн цалин	282,550,162.96	233,458,361.01
210102	Нэмэгдэл	84,945,108.50	148,429,572.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,847,130.50	6,600,000.00
210104	Урамшуулал	29,245,899.00	37,101,797.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	258,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,685,385.92	59,864,901.00
210201	Тэтгэврийн даатгал	34,561,073.70	43,436,154.32
210202	Тэтгэмжийн даатгал	4,167,399.67	3,997,915.95
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,424,385.51	3,334,374.68
210204	Ажилгүйдлийн даатгал	833,499.45	845,737.61
210205	Эрүүл мэндийн даатгал	6,699,027.59	8,250,718.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,834,000.00	51,075,780.10
210301	Гэрэл, цахилгаан	7,157,105.00	5,315,760.00
210302	Түлш, халаалт	8,676,895.00	45,483,490.10
210303	Цэвэр, бохир ус	00.00	276,530.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,955,057.00	30,725,379.00

Төв аймгийн Батсүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210401	Бичиг хэрэг	2,994,400.00	3,588,600.00
210402	Тээвэр, шатахуун	18,429,230.00	20,695,220.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,217,102.00	1,442,459.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,314,325.00	4,999,100.00
2105	Нормативт зардал	33,923,931.00	100,037,972.20
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	24,949,931.00	87,591,947.20
210502	Хоол, хүнс	8,974,000.00	12,446,025.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,934,150.00	11,383,350.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,928,500.00	1,659,980.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,923,750.00	3,990,200.00
210604	Урсгал засвар	3,081,900.00	5,733,170.00
2107	Томилолт, зочны зардал	750,500.00	646,000.00
210702	Дотоод албан томилолт	750,500.00	646,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,132,500.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,558,500.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	00.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	250,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,047,000.00	38,490,310.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,047,000.00	38,490,310.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	47,005,087.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	47,005,087.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	47,005,087.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	6,919,260.12	38,285,365.39
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	16,193,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	16,193,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	16,193,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	16,193,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-16,193,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	6,919,260.12	22,092,365.39
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	22,092,365.39

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	619,849,500.00	576,585,292.61	43,264,207.39	93.0
УРСГАЛ ЗАРДАЛ	619,849,500.00	576,585,292.61	43,264,207.39	93.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	619,849,500.00	576,585,292.61	43,264,207.39	93.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	420,122,500.00	388,787,472.31	31,335,027.69	92.5
Үндсэн цалин	247,345,200.00	227,906,761.01	19,438,438.99	92.1
Нэмэгдэл	128,619,500.00	116,920,614.30	11,698,885.70	90.9
Унаа хоолны хөнгөлөлт	7,056,000.00	6,600,000.00	456,000.00	93.5
Урамшуулал	37,101,800.00	37,101,797.00	3.00	100.0
Гэрээт ажлын хөлс	00.00	258,300.00	-258,300.00	
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,716,200.00	55,186,296.00	1,529,904.00	97.3
Тэтгэврийн даатгал	39,911,400.00	38,757,549.32	1,153,850.68	97.1
Тэтгэмжийн даатгал	4,201,200.00	3,997,915.95	203,284.05	95.2
ҮОМШӨ-ний даатгал	3,361,000.00	3,334,374.68	26,625.32	99.2
Ажилгүйдлийн даатгал	840,200.00	845,737.61	-5,537.61	100.7
Эрүүл мэндийн даатгал	8,402,400.00	8,250,718.44	151,681.56	98.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,082,500.00	49,368,250.10	1,714,249.90	96.6
Гэрэл, цахилгаан	3,465,000.00	3,608,230.00	-143,230.00	104.1
Түлш, халаалт	47,248,500.00	45,483,490.10	1,765,009.90	96.3
Цэвэр, бохир ус	369,000.00	276,530.00	92,470.00	74.9
Хангамж, бараа материалын зардал	31,385,000.00	27,381,169.00	4,003,831.00	87.2
Бичиг хэрэг	4,000,000.00	3,588,600.00	411,400.00	89.7
Тээвэр, шатахуун	18,885,000.00	17,351,010.00	1,533,990.00	91.9
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,500,000.00	1,442,459.00	2,057,541.00	41.2
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,000,000.00	4,999,100.00	900.00	100.0
Нормативт зардал	35,943,300.00	35,889,460.20	53,839.80	99.9
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	24,943,300.00	24,890,940.20	52,359.80	99.8
Хоол, хүнс	11,000,000.00	10,998,520.00	1,480.00	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	11,440,000.00	10,364,870.00	1,075,130.00	90.6
Багаж, техник, хэрэгсэл	4,500,000.00	4,500,000.00	0.00	100.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,040,000.00	3,990,200.00	1,049,800.00	79.2
Урсгал засвар	1,900,000.00	1,874,670.00	25,330.00	98.7
Томилолт, зочны зардал	4,000,000.00	646,000.00	3,354,000.00	16.2
Дотоод албан томилолт	4,000,000.00	646,000.00	3,354,000.00	16.2
Бараа үйлчилгээний бусад зардал	9,160,000.00	8,961,775.00	198,225.00	97.8
Бараа үйлчилгээний бусад зардал	9,160,000.00	8,961,775.00	198,225.00	97.8
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	619,849,500.00	585,600,920.00	34,248,580.00	94.5
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	495,383,000.00	495,383,000.00	0.00	100.0
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	495,383,000.00	495,383,000.00	0.00	100.0
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	52,982,500.00	52,982,500.00	0.00	100.0
Орон нутгийн төсвөөс	52,982,500.00	52,982,500.00	0.00	100.0
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	71,484,000.00	37,235,420.00	34,248,580.00	52.1

Төв аймгийн Батсүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	71,484,000.00	37,235,420.00	34,248,580.00	52.1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00	0.00	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	9,565,627.39	-9,565,627.39	
АЖИЛЛАГСАДЫН ТОО	28.00	28.00	0.00	100.0
Удирдах ажилтан	07.00	07.00	0.00	100.0
Гүйцэтгэх ажилтан	08.00	08.00	0.00	100.0
Үйлчлэх ажилтан	13.00	13.00	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		204,684,517.00
УРСГАЛ ЗАРДАЛ		204,684,517.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		157,679,430.00
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		37,060,558.00
Үндсэн цалин		5,551,600.00
Нэмэгдэл		31,508,958.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		4,678,605.00
Тэтгэврийн даатгал		4,678,605.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		1,707,530.00
Гэрэл, цахилгаан		1,707,530.00
Хангамж, бараа материалын зардал		3,344,210.00
Тээвэр, шатахуун		3,344,210.00
Нормативт зардал		64,148,512.00
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		62,701,007.00
Хоол, хүнс		1,447,505.00
Эд хогшил, урсгал засварын зардал		16,936,480.00
Багаж, техник, хэрэгсэл		13,077,980.00
Урсгал засвар		3,858,500.00
Бараа үйлчилгээний бусад зардал		29,803,535.00
Бараа үйлчилгээний бусад зардал		29,803,535.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		47,005,087.00
Бусад урсгал шилжүүлэг		47,005,087.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		47,005,087.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		94,471,255.00
Нэмэлт санхүүжилтийн орлого		94,471,255.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		79,358,255.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		15,113,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Батсүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад үндсэн хөрөнгийн ашиглах жилийг сунгах, тооллогын бүртгэл, шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 01 дүгээр сарын 25-аас 2022 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Уваа уул Аудит ХХК-ийн аудитор Б.Буяндэлгэр, аудиторын туслах Э.Номинчулуун, Г.Сампилмаа нар гүйцэтгэж, чанар хяналтыг захирал Ч.Мөнхтуяа хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Батсүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Уваа уул аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Батсүмбэр сумын Эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн тухай хуулийн 16.4 дэх заалт, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн дагуу хөдөөгийн хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх чиг үүрэгтэй үйл ажиллагаа явуулдаг Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хууль,
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”,
- Эрүүл мэндийн тухай хууль,
- Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль,
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль,
- Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаал "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам",
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”,
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант хугацаанд Төв аймгийн Санхүү хяналт, аудитын албанаас 2021 оны 11 дүгээр сард хяналт шалгалт хийгдэж алдаа зөрчил илрээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар Төв аймгийн Санхүү хяналт, аудитын албаны гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Батсүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 648,367.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 6,483.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4,538.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзэв.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Батсүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж, 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ний “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:

Тус байгууллага нь 2021 онд Тусгай зориулалтын шилжүүлгээс 495,383.0 мянга, орон нутгийн төсвөөс 52,982.5 мянган төгрөгийн санхүүжилтийг 100.0 хувь авсан.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 94,471.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 765,076.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд 28,623.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 3,658.3 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 30.0 мянган төгрөгийн номын фонд, 275.0 мянган төгрөгийн программ хангамж, нийт 32,587.0 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 2,550.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Бараа материалын дансанд хандиваар 547,896.7 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 724,467.7 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 658,886.0 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Авлага, өглөгийн талаар:

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 22,092.4 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дансгүй байна. Бараа материал 126,082.1 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 371,867.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	22,092.4	22,092.4
Авлага	8,607.5	159,195.9	150,588.3
Бараа материал	60,500.2	126,082.1	65,581.9
Үндсэн хөрөнгө	373,587.9	371,867.2	(1,720.7)
Нийт хөрөнгө	442,695.6	679,237.6	236,542.0
Өглөг	776.1	1,992.0	1,215.9
ЗГ-н оруулсан капитал	410,076.2	410,076.2	-
Хуримтлагдсан үр дүн	(114,177.0)	235,326.0	121,149.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	442,695.6	679,237.6	236,542.0

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 22,092.4 мянган төгрөг байгаа нь Сангийн яамнаас ЭМЯ-ны харьяа байгууллагуудын улсын төсөв, нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдлийг татан төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.
- Авлага дансны үлдэгдэл 150,588.3 мянган төгрөгөөр өссөн нь ЭМДС-аас авах нэмэлт санхүүжилтийг тусгаснаас шалтгаалсан байна.
- Бараа материалын данс өмнөх оноос 65,581.9 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан эм боох материалын дансанд Эрүүл мэндийн газраас 514,044.6 мянган төгрөгийн вакцин авснаас голлон шалтгаалсан байна.
- Үндсэн хөрөнгө дансны өөрчлөлт: Төсвийн хөрөнгөөр 16,193.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, эд хогшил худалдан авсан, Төв аймгийн Эрүүл мэндийн газраас 12,434.0 мянган, аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс хандив тусламжаар 2,550.0 мянган төгрөгийн хөрөнгө тус тус орлогод авснаас шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус Эрүүл мэндийн төвийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 678,878.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 53,000.0 мянган төгрөг, ЭМДСангаас урсгал зардалд 803,362.0 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөж төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс урсгал зардлыг 183,512.0 мянган төгрөгөөр бууруулан 619,849.5 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар улсын төсвөөс 495,383.0 мянга, орон нутгийн төсвөөс 52,982.5 мянга, ЭМДСангаас 37,235.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 576,035.3 мянган төгрөгийг зарцуулж, 9,565.6 мянган төгрөгийг үлдэгдэлтэй гарсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 576,585.3 мянган төгрөг буюу 93.0 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 94,471.3 мянган төгрөг төвлөрч, цалин хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ-н зардалд 41,739.2 мянган, Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардалд 62,701.0 мянган, Эд хогшил, урсгал засварын зардалд 16,936.5 мянган, бараа үйлчилгээний бусад зардалд 29,803.5 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Үндсэн хөрөнгө дансанд 28,623.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 3,658.3 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 30.0 мянган төгрөгийн номын фонд, 275.0 мянган төгрөгийн программ хангамж, нийт 32,587.0 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 30,037.0 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 2,550.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Хэвтэн эмчлүүлэгчийн тусламж үйлчилгээ, амбулаторийн тусламж үйлчилгээ болон оношилгоо шинжилгээний тусламж үйлчилгээ буурч зөвхөн ковидын тусламж үйлчилгээ үзүүлснээс үүдэн ЭМДС-аас авах санхүүжилт 34,248.6 мянган төгрөгөөр буурсан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Батсүмбэр сумын Эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 147 мэдээллийг хугацаандаа, 2 мэдээллийг байршуулаагүй зөрчилтэй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгахад шалгагдагч байгууллага нь Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу төсвийн гүйцэтгэлийн тайлангаа бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төсвийн гүйцэтгэлийн тайлангаа иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй, хөрөнгө

худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 54.5, Засгийн газрын 2021 оны 43-р тогтоолын 1.4 дэх заалттай тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 5 алдаа зөрчилд 890.4 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 20,617.9 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 34,845.8 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Шилэн дансны цахим хуудсанд хугацаа хоцроож мэдээлэл байршуулсан зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Хугацаа хоцорсон мэдээлэл байхгүй боловч таван саяас дээш дүнтэй орлого, зарлагын гүйлгээг дутуу байршуулсан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллага дээр ажиллаж хөрөнгийн биет тооллого хийх нөхцөл байдал хязгаарлагдмал байгааг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 710,200.6 мянган төгрөгийн 4 алдаа зөрчилд 710,200.6 мянган төгрөгийн 1 алдааг залруулан, залруулаагүй алдааг зөрчилд 3 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-үндсэн хөрөнгө 120017 дансанд бүртгэх ёстой 554,527.0 мянган төгрөгийн орлогыг 1200045 дансанд бүртгэсэнд залруулга хийлгэв.
- ЭМДС-аас авах авлага болох 155,673.6 мянган төгрөгийн авлага тусгуулсан.

Шийдвэрлэсэн нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын дагуу залруулга хийлгэв.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй болно.

4.3 Албан шаардлага

Төв аймгийн Батсүмбэр сумын Эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 147 мэдээллийг хугацаандаа, 2 мэдээллийг байршуулаагүй зөрчилтэй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3."тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй тул албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 207,302.3 мянган төгрөгийн хөрөнгө байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" тогтоолын 7.1-д "төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн аудитын "үнэлгээ ба хуваарилалт" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

ТӨБЗГ-н тогтоолын хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн ашиглах жил, үнийг шинэчлэн тогтоох, зөрчлийг давтан гаргахгүй байх

2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн тооллогын баримтад эд хариуцагчийг карт, тооцоо бодсон баримт, тооллогын комиссын илтгэх хуудас, өмч хамгаалах зөвлөлийн тэмдэглэл, байгууллагын удирдлагад танилцуулсан тэмдэглэл, тооллогын баталгаа хийгдээгүй зэрэг нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч, ерөнхий нягтлан бодогч нь тооллого эхлэхийн өмнө дараах бэлтгэл хангасан байх үүрэгтэй...", 72 дугаар зүйлийн 72.4-д "Тооллогын комисс дараах үүрэгтэй..."

гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн аудитын “үнэлгээ ба хуваарилалт”, “тохиолдсон байх”, “үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Тооллогыг ажлыг чанартай явуулж холбогдох хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

3. Авлага, өглөгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Харилцахын үлдэгдэл, авлага, өглөгийн тооцоог жилийн эцсээр нийлж баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай тус нийцэхгүй, санхүүгийн аудитын “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Харилцагч байгууллага, иргэдтэй тооцоо нийлж авлага, өр төлбөрийг барагдуулах ажлыг зохион байгуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Төв аймгийн Батсүмбэр сумын Эрүүл мэндийн төв	6	710,200.6	2	710,200.6			1	-	3	-
	ДҮН	6	710,200.6	2	710,200.6			1	-	3	-

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт:
www.audit.mn